

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Батширээт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2026/104/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

Audit.mn

Хэнтий аймаг

Чингис хот

2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112 мэйл хаяг: Khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390 мэйл хаяг: Oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Энх-Амгалан
Утас: 91119424 мэйл хаяг: Enkh-Amgalang@audit.gov.mn

Ари файнэнс аудит ХХК-ийн Захирал: Д.Ариунаа
Утас: 99088151 мэйл хаяг: arifin.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2026.02.24 № 258

танай _____ -ны № _____ -т

Г Өөрчлөлтгүй дүгнэлт 7

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1,8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Батширээт сумын Ерөнхий боловсролын сургууль 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүү байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангилал тус бүрээр бус “бараа үйлчилгээний бусад зардал” ангиллаар нэгтгэн төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 12,900.3 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 12,690.4 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 209.9 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт хүргүүлээ.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Батширээт сумын Ерөнхий боловсролын сургууль нь гүйцэтгэлийн төлөвлөгөөний чанарын болон тоо хэмжээний 20 зорилтын хүрээнд 54 арга хэмжээ төлөвлөснөөс гүйцэтгэл

70.3 хувьтай дүгнэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	336,254,253.30	308,972,470.81
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	233,372,110.99	194,021,625.48
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	233,372,110.99	194,021,625.48
31210	Төгрөг	233,372,110.99	194,021,625.48
31211	Төрийн сангийн харилцах	233,372,110.99	194,021,625.48
33	АВЛАГА	-	1,092,783.47
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	1,092,783.47
35	БАРАА МАТЕРИАЛ	102,882,142.31	113,858,061.86
35100	Түүхий эд материал	46,386,998.76	48,200,898.76
35110	Тусгай зориулалттай материал	46,386,998.76	48,200,898.76
35300	Бэлэн бүтээгдэхүүн	19,002,910.00	17,828,700.00
35400	Хангамжийн материал	37,492,233.55	47,828,463.10
35410	Бичиг хэргийн материал	1,499,000.00	1,095,000.00
35420	Аж ахуйн материал	4,219,000.00	3,951,000.00
35440	Түлш, шатах тослох материал	448,800.00	-
35460	Хүнсний материал	741,002.00	9,736,856.00
35470	Бусад хангамжийн материал	30,584,431.55	33,045,607.10
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,257,356,953.21	5,236,110,086.52
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,257,356,953.21	5,236,110,086.52
39200	Биет хөрөнгө	5,201,034,953.21	5,179,788,086.52
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,476,781,293.74	5,621,404,738.01
39202	Хуримтлагдсан элэгдэл	(499,987,294.65)	(633,272,210.96)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	255,108,401.08	257,421,246.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	(89,703,584.65)	(103,984,591.83)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	93,494,532.00	63,557,858.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(57,119,502.63)	(34,777,041.95)
39217	Ном	22,461,108.32	9,438,088.35
39300	Биет бус хөрөнгө	56,322,000.00	56,322,000.00
39301	Програм хангамж	67,000.00	67,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(67,000.00)	(67,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	56,322,000.00	56,322,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	5,593,611,206.51	5,545,082,557.33
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	18,496,427.41	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	18,496,427.41	-
41300	Өглөг	18,496,427.41	-

Хэнтий аймгийн Батширээт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

41360	Бусад өглөг	18,496,427.41	-
41361	Байгууллагад төлөх өглөг	18,496,427.41	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,575,114,779.10	5,545,082,557.33
51	Засгийн газрын хувь оролцоо	5,575,114,779.10	5,545,082,557.33
51100	Засгийн газрын оруулсан капитал	295,438,231.39	295,438,231.39
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	295,438,231.39	295,438,231.39
51200	Хуримтлагдсан үр дүн	4,826,332,714.21	4,796,300,492.44
51210	Өмнөх үеийн үр дүн	4,887,381,603.23	4,813,309,694.24
51220	Тайлант үеийн үр дүн	(61,048,889.02)	(17,009,201.80)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	453,343,833.50	453,343,833.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,593,611,206.51	5,545,082,557.33

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,642,572,809.40	2,058,154,566.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	50,376,309.40	2,058,154,566.00
120	Нийтлэг татварын бус орлого	50,376,309.40	159,649,066.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,225,800.00	122,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,120,800.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	105,000.00	122,500.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	37,027,720.00	150,600,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	12,122,789.40	8,926,566.00
122	Тусламжийн орлого	-	1,898,505,500.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	1,898,505,500.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	1,898,505,500.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	1,582,371,200.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	316,134,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,592,196,500.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,315,286,200.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,315,286,200.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	276,910,300.00	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	276,910,300.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,426,606,398.42	2,069,597,477.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,426,606,398.42	2,069,597,477.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,375,298,238.42	1,975,665,988.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	958,228,168.87	1,220,391,257.00
210101	Үндсэн цалин	655,607,414.54	722,576,849.89
210102	Нэмэгдэл	282,342,204.33	410,820,480.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	33,020,000.00
210104	Урамшуулал	20,278,550.00	53,973,926.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	114,630,950.68	145,811,421.03
210201	Тэтгэврийн даатгалын зардал	81,246,756.20	100,180,797.24
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	9,084,031.49	12,485,340.08
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	4,462,815.74	6,083,290.75
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	3,954,018.63	5,412,399.08

Хэнтий аймгийн Батширээт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	15,883,328.62	21,649,593.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	269,268,871.15
210301	Гэрэл, цахилгаан	-	19,381,664.75
210302	Түлш, халаалт	-	238,874,706.40
210303	Цэвэр, бохир ус	-	11,012,500.00
2105	Нормативт зардал	68,018,042.00	87,515,946.00
210502	Хоол, хүнс	68,018,042.00	87,515,946.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,999,500.00	20,000,000.00
210604	Урсгал засвар	2,999,500.00	20,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,583,903.81	19,526,636.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,120,800.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	16,463,103.81	19,526,636.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	213,837,673.06	213,151,856.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,077,180.20	28,774,510.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,199,170.00	6,624,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	179,561,322.86	177,752,846.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,308,160.00	93,931,488.85
2131	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	26,865,428.85
2131121	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	26,865,428.85
2132	Бусад урсгал шилжүүлэг	51,308,160.00	67,066,060.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	51,308,160.00	67,066,060.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	12,225,748.39	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,225,748.39	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(61,048,889.02)	(11,442,911.35)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	5,566,290.45
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	-	5,566,290.45
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-	(5,566,290.45)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(61,048,889.02)	(17,009,201.80)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,593,422,300.00	1,898,628,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,225,800.00	1,898,628,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,225,800.00	122,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,225,800.00	122,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,120,800.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	105,000.00	122,500.00
122	Тусламжийн орлого	-	1,898,505,500.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	1,898,505,500.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	1,898,505,500.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	1,582,371,200.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\		316,134,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,592,196,500.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,315,286,200.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,315,286,200.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	276,910,300.00	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	276,910,300.00	
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,510,040,766.15	1,919,049,485.51

Хэнтий аймгийн Батширээт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,510,040,766.15	1,919,049,485.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,442,882,717.76	1,826,292,206.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	948,957,698.60	1,239,980,467.88
210101	Үндсэн цалин	642,259,224.66	742,166,060.77
210102	Нэмэгдэл	279,379,320.32	410,820,480.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	33,020,000.00
210104	Урамшуулал	27,319,153.62	53,973,926.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	104,724,993.54	145,811,421.03
210201	Тэтгэврийн даатгалын зардал	71,340,799.08	100,180,797.24
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	9,084,031.49	12,485,340.08
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	4,462,815.74	6,083,290.75
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	3,954,018.63	5,412,399.08
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	15,883,328.60	21,649,593.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	261,790,051.61	269,268,871.15
210301	Гэрэл, цахилгаан	12,101,640.63	19,381,664.75
210302	Түлш, халаалт	240,988,410.98	238,874,706.40
210303	Цэвэр, бохир ус	8,700,000.00	11,012,500.00
2105	Нормативт зардал	67,315,220.00	96,511,800.00
210502	Хоол, хүнс	67,315,220.00	96,511,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,999,500.00	20,000,000.00
210604	Урсгал засвар	2,999,500.00	20,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,968,903.81	19,476,636.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,120,800.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	21,848,103.81	19,476,636.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,126,350.20	35,243,010.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,404,580.20	27,987,610.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,721,770.00	7,255,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,158,048.39	92,757,278.85
2131	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	26,865,428.85
2131121	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	26,865,428.85
2132	Бусад урсгал шилжүүлэг	54,932,300.00	65,891,850.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	54,932,300.00	65,891,850.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	12,225,748.39	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,225,748.39	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	83,381,533.85	(20,421,485.51)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	17,785,000.00	18,929,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,785,000.00	18,929,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	17,785,000.00	18,929,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	17,785,000.00	18,929,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(17,785,000.00)	(18,929,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	65,596,533.85	(39,350,485.51)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	167,775,577.14	233,372,110.99
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	233,372,110.99	194,021,625.48

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 1-нээрх үлдэгдэл	295,438,231.39	453,343,833.50	4,826,332,714.21	5,575,114,779.10
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	295,438,231.39	453,343,833.50	4,826,332,714.21	5,575,114,779.10
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	295,438,231.39	453,343,833.50	4,826,332,714.21	5,575,114,779.10
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	295,438,231.39	453,343,833.50	4,826,332,714.21	5,575,114,779.10
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(13,023,019.97)	(13,023,019.97)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	295,438,231.39	453,343,833.50	4,813,309,694.24	5,562,091,759.13
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(17,009,201.80)	(17,009,201.80)
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	295,438,231.39	453,343,833.50	4,796,300,492.44	5,545,082,557.33

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,928,316,300.0	1,871,762,571.2	56,553,728.8	97.1
12	Татварын бус орлого	1,928,316,300.0	1,871,762,571.2	56,553,728.8	97.1
120	Нийтлэг татварын бус орлого	122,500.0	122,500.0	-	100.0
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	122,500.0	122,500.0	-	100.0
122	Тусламжийн орлого	1,928,193,800.0	1,871,640,071.2	56,553,728.8	97.1
122005	Төсвөөс санхүүжих	1,612,059,500.0	1,582,371,200.0	29,688,300.0	98.2
122005	Төсвөөс санхүүжих	316,134,300.0	289,268,871.2	26,865,428.9	91.5
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,159,473,400.0	1,911,113,056.7	248,360,343.3	88.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,159,473,400.0	1,911,113,056.7	248,360,343.3	88.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,092,006,500.0	1,845,221,206.7	246,785,293.3	88.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,426,792,300.0	1,239,980,467.9	186,811,832.1	86.9
210101	Үндсэн цалин	879,130,500.0	742,166,060.8	136,964,439.2	84.4
210102	Нэмэгдэл	510,974,800.0	410,820,480.9	100,154,319.1	80.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	33,020,000.0	(33,020,000.0)	
210104	Урамшуулал	36,687,000.0	53,973,926.2	(17,286,926.2)	147.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	178,348,900.0	145,811,421.0	32,537,479.0	81.8
210201	Тэтгэврийн даатгал	121,277,300.0	100,180,797.2	21,096,502.8	82.6
210202	Тэтгэмжийн даатгал	14,268,000.0	12,485,340.1	1,782,659.9	87.5

Хэнтий аймгийн Батширээт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210203	ҮОМШӨ-ний даатгал	7,133,900.0	6,083,290.8	1,050,609.3	85.3
210204	Ажилгүйдлийн даатгал	7,133,900.0	5,412,399.1	1,721,500.9	75.9
210205	Эрүүл мэндийн даатгал	28,535,800.0	21,649,593.9	6,886,206.1	75.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	296,134,300.0	269,268,871.2	26,865,428.9	90.9
210301	Гэрэл, цахилгаан	22,000,000.0	19,381,664.8	2,618,335.3	88.1
210302	Түлш, халаалт	263,121,300.0	238,874,706.4	24,246,593.6	90.8
210303	Цэвэр, бохир ус	11,013,000.0	11,012,500.0	500.0	100.0
2105	Нормативт зардал	96,517,800.0	96,511,800.0	6,000.0	100.0
210502	Хоол, хүнс	96,517,800.0	96,511,800.0	6,000.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,000,000.0	20,000,000.0	-	100.0
210604	Урсгал засвар	20,000,000.0	20,000,000.0	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,133,100.0	22,796,636.6	336,463.4	98.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	23,133,100.0	22,796,636.6	336,463.4	98.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,080,100.0	50,852,010.0	228,090.0	99.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,824,500.0	43,596,610.0	227,890.0	99.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,255,600.0	7,255,400.0	200.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,466,900.0	65,891,850.0	1,575,050.0	97.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	67,466,900.0	65,891,850.0	1,575,050.0	97.7
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	67,466,900.0	65,891,850.0	1,575,050.0	97.7
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(231,157,100.0)	(39,350,485.5)	(191,806,614.5)	17.0
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	231,157,100.0	39,350,485.5	191,806,614.5	17.0
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	231,157,100.0	39,350,485.5	191,806,614.5	17.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	233,372,111.0	(233,372,111.0)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	194,021,625.5	(194,021,625.5)	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 12,900.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 209.9 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 12,690.5 мянган төгрөгийн зөрчилд¹ 3 албан шаардлага хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

1. Сахилгын арга хэмжээтэй байх хугацаанд үр дүнгийн урамшууллыг давхардуулж олгосон байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байх”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон. Биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны дотор ирүүлэх

3.2 Албан шаардлага

1. Байгууллагын даргын тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого зохион байгуулах комиссыг томилж хөрөнгийн тооллогыг гүйцэтгүүлсэн боловч тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2. "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1. "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" заалт; 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." заалтууд, санхүүгийн тайлангийн "үнэлгээ", "үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн. Биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны дотор ирүүлэх

2. Ур чадварын нэмэгдлийг хагас жил тутам холбогдох шалгуур үзүүлэлтүүдээр үнэлж, дүгнэдэггүй зөвхөн тухайн үеийн гаргасан амжилтыг үнэлж нэмэгдэл олгодог, журмын дагуу олгоогүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 сарын 01-ний өдрийн А/35, А/102 дугаар хамтарсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтын 10 дахь “Энэхүү баримт бичгийн 4,5-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн үнэлгээнд 60.0 ба түүнээс дээш хувь үнэлэгдсэн багш, ажилтны ажлын үр дүн, манлайлал, мэргэжлийн хөгжлийн ахиц дэвшил, амжилтын түвшнийг харгалзан нэмэгдлийг дараах хувиар тогтооно. “цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10 хувь”, “сумын түвшинд 15 хувь, ” аймаг, нийслэлийн түвшинд 20 хувь, ” улс, бүс, олон улсын амжилт гаргасан түвшинд 25 хувь,” гэсэн заалтыг зөрчиж, “иж бүрэн байх” нийцсэн бөгөөд зохистой байх”, “толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн. Биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны дотор ирүүлэх

3. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх Засгийн газрын өмчийн дүн санхүүгийн тайлан дахь өмчийн дүн зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх"; 13 дугаар зүйлийн 13.1. “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”; Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалтыг зөрчиж, “үнэн зөв байх”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн. Биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны дотор ирүүлэх

Хэнтий аймгийн Батширээт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Сахилгын арга хэмжээтэй байх сард үр дүнгийн урамшууллыг давхардуулж олгосон	1	209.9	1	209.9								
Байгууллагын даргын тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого зохион байгуулах комиссыг томилж хөрөнгийн тооллогыг гүйцэтгүүлсэн боловч тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.	1	0			1	0						
Ур чадварын нэмэгдлийг хагас жил тутам холбогдох шалгуур үзүүлэлтүүдээр үнэлж, дүгнэдэггүй зөвхөн тухайн үеийн гаргасан амжилтыг үнэлж нэмэгдэл олгодог, журмын дагуу олгоогүй байна.	1	12,690.4			1	12,690.4						
Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх Засгийн газрын өмчийн дүн санхүүгийн тайлан дахь өмчийн дүн зөрүүтэй байна.	1	0			1							
Дүн	4	12,900.3	1	209.9	3	12,690.4						